



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 8/097

Улаанбаатар хот

**Газар эзэмших эрхийг бусдад
шилжүүлэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 6 (зургаан) иргэний газрыг хавсралтад зааснаар шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг шилжүүлэн авсан иргэнтэй холбогдох хууль тогтоомж, эрхийн актын дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/131 дүгээр захирамжийг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД